



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 19 өдөр

Дугаар A/565

Арвайхээр

### Аймгийн бэлчээр ашиглалтын журам

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” 03/02 дугаар тогтоолын 2.4.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.“Аймгийн бэлчээр ашиглалтын журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.“Аймгийн бэлчээр ашиглалтын журам”-ыг хэрэгжүүлж, малчдад сурталчилж, орон нутагтаа бэлчээр ашиглалтын менежментийн төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжүүлж ажиллахыг сумын иргэдийн Хурал, Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Журмыг хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011101188

Аймгийн Засаг даргын 2021 оны...11...  
дугаар сарын ...10...-ны өдрийн..A/5.65  
дугаар захирамжийн хавсралт

## АЙМГИЙН БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Өвөрхангай аймаг нь газрын нэгдмэл сангийн ангиллаар нийт газар нутгийн хэмжээ 6,289,533га, үүнээс 89.8 хувь буюу 5,642,103га нь бэлчээр нутаг юм. Бэлчээр нутгийг авч үзвэл өндөр уулын бусэд 10.8, ойт хээрийн бусэд 19.4, хээрийн бусэд 25.6, цөлөрхөг хээрийн бусэд 44.2 хувь нь хамаардаг. Нийт бэлчээр нутгийн 10 орчим хувийг алс зэлүүд, даваа бартаа, саад ихтэй гэдэг шалтгаанаар ашиглаж чадахгүй байна.

Аймгийн хэмжээнд өвөл-хаврын, зун-намрын гэсэн бэлчээр ашиглалтын хэлбэр зонхилдог. Бэлчээр сэлгэх ойрын болон алсын отор нүүдэл хийх байдал үндсэндээ орхигдон төв суурин газар, ил задгай устай бэлчээрийг жилийн туршид ашиглаж байгаа нь цэгэн талхлагдалт үүсгэж байна. Малын эрүүл мэнд ногоон алт төслөөс нийт бэлчээрийн 24.2 хувь буюу 1.3 сая га нь унаган төрхөө алдаж эргэн сэргэхэд 5-8 жил шаардлагатай бөгөөд бэлчээрийн 65 хувь нь доройтоож байна гэсэн судалгааг гарсан байна.

Дээрх байдлаас үүдэн сүүлийн 4 жилийн байдлаас харахад мал сүргийн тоо толгой жил дараалан өсч улмаар бэлчээрийн даац 3-5 дахин хэтэрч, мөн нийт нутгийн 60 гаруй хувь нь гандуу байснаас мал тарга, хүчээ бүрэн авч чадахгүй жил дараалан гадны аймаг, сумдад отор нүүдэл хийж байна.

Бэлчээр доройтоход шимт ургамал цөөрсний улмаас мал сүрэгт махан тарга авахуулдаг ургамал давжаарч, сийрэгжин 1га дахь ургамлын масс буурах, нэг наст хог ургамал ургаж, ургамлын хооронд халцарч, нүцгэрсэн газар ихсэн шороон шуурга элбэгшиж, үржил шимт хөрс элэгдэлд орж байна. Энэ бүхэн малд тохиромжгүй хог ургамал үржих, тархах орчин бүрдүүлдэг ба бэлчээрийн үндсэн ургамал сэргэх нөхцөлийг улам бүр хумъж байгаагаас шалтгаалан бэлчээр ашиглалтын журам гаргаж мөрдүүлэх зайлшгүй шаардлага гарч байна.

Энэ журам нь Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.2, 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, 52.4-52.6, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2, 21 дүгээр зүйлийн 1-д заасан харилцаанд нийцсэн байна.

Хоёр. Журмын зорилго

Бэлчээр ашиглалтыг тухайн орон нутгийн бэлчээрийн экологийн чадавхид суурилсан аргачлалаар төлөвлөх, бэлчээрийн даацад тохирсон мал сүрэг өсгөн үржүүлэх, ашиглалтыг сайжруулах, хамгаалах, нөхөн сэргээх, нутгийн удирдлага болон бэлчээр ашиглагчдын хооронд үүсэх харилцааг зохицуулах, хяналт үнэлгээ хийхэд оршино.

Гурав. Журмыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллагуудын хүлээх үүрэг

3.1 Хүнс, хөдөө аж ахуйн газар:



3.1.1. Бэлчээр ашиглаж ирсэн уламжлалт арга, түүнийг шинжлэх ухааны ололтоор баяжуулан доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах талаар малчдад сургалт зохион байгуулж, бэлчээрийг зөв ашиглах дадлыг бий болгоход дэмжлэг үзүүлэх

3.1.2. Фото мониторингийн дүн мэдээлэлд тулгуурлан тухайн жилд малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, сургийн зохистой бүтэц, харьцаа, чанар болон мал аж ахуйн менежментийн бусад асуудлаар зөвлөмж гаргаж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх

3.1.3. Бэлчээрийн хүрэлцээ, хангамжийг тооцон хонин толгойд шилжүүлснээр тухайн жилд өвөлжиж, хаваржих малын тооны дээд хязгаарыг тогтоон сум, багуудад зөвлөмж хүргүүлэх

3.1.4. Бэлчээрийн даацаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, нэмэгдэл тэжээлээр тэжээх, отор нүүдэл хийх ажлыг зохион байгуулах

3.1.5. Сумдын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу хийж хэрэгжүүлсэн ажилд хяналт үнэлгээ хийх

### 3.2 Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар:

3.2.1. Бэлчээр, хадлангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд хийх

3.2.2. Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулахад шаардагдах хавсралт, зурган мэдээлэл гаргах, бэлчээр ашиглалтын гэрээг газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, фото мониторингийн дунд үндэслэн гэрээний хэрэгжилтийг үнэлэх, тайлагнах

### Дөрөв. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хүлээх үүрэг

4.1 Сумын Засаг даргын ажлыг үнэлэхдээ сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөө болон аймгийн бэлчээр ашиглалтын журмын хэрэгжилтийн үр дүнг харгалзан үзэх

4.2 Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн бусад аймаг, сум, багаас бэлчээрийн даац хүрэлцээтэй өөрийн аймгийн сум, багийн нутаг дэвсгэрт малчин өрх, мал оруулахдаа тухайн сумын Засаг даргатай зөвшилцөн шийдвэрлэх

### Тав. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын хүлээх үүрэг:

5.1 Жил бүр сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөө батлан, малын тоо толгойн албан татварын орлогоос бэлчээрийн менежментийг сайжруулахад хөрөнгө хуваарилж, үр дүнд хяналт тавих

5.2 Багийн бэлчээрт фотомониторинг хийж болох цэгийг шинэчлэн тогтоох саналыг мэргэжлийн байгууллагад хүргүүлэх

5.3 Жил бүр сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэх

5.4 Өвөлжөө, хаваржааныхаа (0.07 га газрынхаа зэргэлдээ 0.1 га газарт) гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориуulan хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал

ургамал тарих зориулалтаар төлбөргүй эзэмшүүлж болно гэсний дагуу хашиж хамгаалах шийдвэр гаргах

5.5 Сумын нутаг дэвсгэрээр отор нүүдэл дайран өнгөрөх хоног хугацаа, зам маршрутыг тогтоож мөрдүүлэх

5.6 Цаг хүндрээгүй үед өөрийн аймгийн бусад сумдаас ирсэн отор нүүдлийг хүлээн авахгүй байх, орж ирсэн отрын айл өрхийг албадан нүүлгэх

5.7 Шаардлагатай тохиолдолд хужир мараа, таананд мал оруулах тохиолдолд холбогдох сумдын Засаг дарга нар зөвшилцөн айлын өвөлжөө хаваржаанаас алсуур нутаг бэлчээр болон хугацааг заан оруулж гаргах

5.8 Сум дундын отрын бүс нутагт шинээр гарсан инженерийн хийцтэй худгийг ЗДТГ эзэмшиж, ашиглалт хамгаалалтыг хариуцах

## 6 Малчдын хүлээх үүрэг

6.1 Малчдын бүлэг, аравт, нөхөрлөл зэрэг хамтын зохион байгуулалтад нэгдэн бэлчээр ашиглах үйл ажиллагаанд оролцох

6.2 Малчин өрх нь тухайн багийн бэлчээрийн даацаад тохирсон малыг өсгөн үржүүлэх бөгөөд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон малын тоо толгойн албан татварыг хугацаанд нь төлөх

6.3 Бэлчээрийг өнжөөх, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх талаар гарсан шийдвэрийг дагаж биелүүлэх

6.4 Тогтоосон журмын дагуу нэгдсэн зохицуулалтаар малын хөлөөс чөлөөлсөн бэлчээрт дураар мал оруулахгүй байх

6.5 Бэлчээр, усны эхийг хог хаягдал, хортой зүйлс, сэг зэмээр бохирдуулахгүй байх

6.6 Бэлчээрт шинээр дур мэдэж өвөлжөө, хаваржаа, барилга байшин барих, суваг шуудуу татах, бэлчээр хаших, торлохгүй байх

6.7 Гаднаас дур мэдэж айл өрх, мал сүрэг оруулах, өвөлжөө, хаваржаа, хонд бууцыг бусдад дамжуулан ашиглуулах, хураамж авахгүй байх

6.8 Зуншлага намаржилт хэвийн үед өөрийн аймгийн бусад сумдад отор нүүдэл хийхгүй байх

6.9 Малын урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдаагүй, эрүүл мэндийн дэвтэргүй малыг сүм, багийн нутаг дэвсгэрт оруулахгүй байх

6.10 Өвөлжөө, хаваржааны хамтын хэрэгцээний хуулиар тогтоосон 0.1га газарт малын тэжээлийн ургамал тарихалах

## Долоо. Хариуцлага

7.1. Энэхүү шийдвэрийг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжийн дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ.

## Найм. Дагаж мөрдөх хугацаа

8.1. Энэхүү журмыг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.